



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023

Агуулга

ХУРААНГУЙ ТАЙЛАН	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
Дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт: Төрийн аудитын байгууллагын 2023 оны “Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах” зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар ажлын дэд төлөвлөгөө боловсруулан дараах 6 арга хэмжээг тусгасан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд:	7
Бүтэц, зохион байгуулалт: Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/02 тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.	11
Захиргааны ерөнхий хуулийн 103 дахь заалтын хэрэгжилт:	13
ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН АУДИТ	13
Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн:	14
Ерөнхий чиглэлийн хэрэгжилт	15
Санхүүгийн тайлангийн аудитын онцлог	15
Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө	15
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	16
Аудитын үр нөлөө	17
Аудитын үр нөлөө	18
“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн аудит	18
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ;	19
“Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх”	20
ТАВДУГААР БҮЛЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ	21
Аудитын үр нөлөө	22
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ	22
ДОЛООДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	28

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АНУЗГ	Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
БШУГ	Баримт нягтлан шалгах комисс
БОАЖГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗББН	Зохион байгуулалтын бүтцийн нэгж
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МТТ	Мэдээллийн технологийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит ах ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ӨХСЗ	Өмч хамгаалах салбар зөвлөл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТАС	Санхүүгийн тайлангийн аудитын систем
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүү, хяналт аудитын алба
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ХАК	Хувийн аудитын компани
ХАСХОМ	Хөрөнгө ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХБТГ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.11.30

Баянхонгор хот

ХУРААНГУЙ ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2023 онд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 11 дүгээр зүйлийн 11.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/04 тушаал, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/22 тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар бодлогоор гүйцэтгэх гүйцэтгэлийн 3, нийцлийн 1, хуулийн дагуу гүйцэтгэлийн 2, аймгийн ИТХ-ын болон өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн 1, хуулийн дагуу 6 (үүнээс орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулсантай холбогдуулан 2 гүйцэтгэлийн, 3 нийцлийн, Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх 1) нийтдээ шууд тайлагнах 10, санхүүгийн тайлангийн аудитад 269 байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийлээ.

Хүний нөөц

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2023 онд 12 орон тоотойгоор ажиллахаас 2023 оны 11 дүгээр сараас эхлэн аудиторын 2 орон тоо сул нөхөгдөж 12 орон тоогоор бүрэн ажилласан ба дунджаар 21384 хүн/цаг ажиллахаас 21248 хүн/цаг буюу 1651 хүн/цаг илүү ажиллан дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэв.

Аудитын дүн

- Санхүүгийн тайлангийн аудитад 269 хамрагдсанаас 97 байгууллагад Төрийн аудитын газар, 40 байгууллагад хувийн аудитын хуулийн этгээд аудит хийн дүгнэлт гаргаж, 132 байгууллагыг түүвэрт хамруулсан. Дүгнэлт гаргасан 137 байгууллагаас 120 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 17 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.
- 2023 онд гүйцэтгэсэн санхүү, гүйцэтгэл болон нийцлийн аудитаар нийт 26,370.6 сая төгрөгийн 953 алдаа, зөрчил илэрснээс 2,481.9 сая төгрөгийн 106 алдааг санхүүгийн тайланд залруулж, 23,888.7 сая төгрөгийн 847 зөрчил илэрснээс 748.7 сая төгрөгийн 187 төлбөрийн акт тогтоосноос 711.9 сая (95.1%), зөрчлийг арилгах 14,877.4 сая төгрөгийн 207 албан шаардлага хүргүүлснээс 12,929.3 сая (86.9%), зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 7,480.9 сая төгрөгийн 434 заалт бүхий зөвлөмж өгснөөс 6,428.3 сая (85.9%) төгрөгийн зөрчлийг арилгаж, сахилгын шийтгэл ногдуулах 618.8 сая төгрөгийн 16 албан шаардлагыг хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж, хууль хяналтын байгууллагад 162.9 сая төгрөгийн 3 зөрчлийг шилжүүлсэн.

Нийт шийдвэрийн хэрэгжилтийн дундаж хувь 94.7 хувьтай байгаа нь 1,422.6 сая төгрөгийн 21 шийдвэрийн хэрэгжилт тооцох хугацаа болоогүйтэй холбоотой байна.

Хугацаа болоогүй шийдвэрийн хэрэгжилтийг хасаж тооцвол төлбөрийн актын 96.1%, албан шаардлагын 89.6%, зөвлөмжийн 99.4%, нийт дүнгээр хэрэгжилт 97.5%-ийн биелэлттэй байна.

Хүснэгт №1. 2023 оны шийдвэрийн хэрэгжилт

сая.төг

Үзүүлэлт	Тогтоосон		Хэрэгжсэн			Хугацаа болоогүй		Биелэлт	
	Тоо	дүн	Тоо	дүн	Хувь	Тоо	дүн	ХБГ	Хувь
Төлбөрийн акт	187	748.7	182	711.9	95.1	1	7.6	719.5	96.1
Албан шаардлага	207	14,877.4	191	12,929.3	86.9	7	406.0	13,335.3	89.6
Зөвлөмж	434	7,480.9	416	6,428.3	85.9	13	1,009.0	7,437.3	99.4
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	16	618.8	16	618.8	100			618.8	100.0
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	3	162.9	3	162.9	100			-	0.0
Залруулга	106	2481.9	106	2,481.9	100			2,481.9	100
Нийт зөрчлийн дүн	953	26370.6	914	23,333.1	94.7	21	1,422.6	24,605.7	97.5

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь ТАГ-ын 2023 оны статистик мэдээ

Сургалт

Төрийн аудитын байгууллагын 2023 онд дэвшүүлсэн "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах" зорилтын ТАБ-аас болон байгууллагын дотоод сургалтаар 5 чиглэлээр 16 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулан Газрын дарга, тэргүүлэх аудитораар 2023.03.01-ны өдөр батлуулсан, сургалтын төлөвлөгөөнд ҮАГ-аас Datashool-д албан хаагчдыг хамруулахаар болсонтой холбогдуулан 2 зорилтыг нэмж төлөвлөсөн.

ТАБ-ын нэгдсэн сургалтын болон байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2023 онд 6 зорилтын хүрээнд 43 удаагийн сургалт, хэлэлцүүлгээр 684 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан.

ТАГ-ын 2023 онд хэрэгжүүлсэн сургалтаас дараах үр дүнгүүд гарсан. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын 2023 оны цахим сургалт зохион байгуулах төлөвлөгөөний дагуу 6 сэдэвт сургалтад 15 албан хаагч хамрагдаж 13 сертификат нэмэгдсэн.
- "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах" зорилтын хүрээнд аймгийн төвийн болон сумдын төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч, нярав нарт "Санхүүгийн тайлангийн 2022 оны аудитын үр дүн" сэдэвт сургалтаар СТА-аар илэрсэн нийтлэг зөрчил, зөрчигдөж буй хууль тогтоомжийн заалт, хэрэгжээгүй шийдвэрийн хэрэгжилтийн талаар танхимаар болон цахим, газар дээр нь хүрч ажилласнаас Санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийн хэрэгжилт 97 хувийн биелэлттэй ажилласан.
- Datashool цахим сургалтад ТАГ-ын 8 албан хаагч хамрагдсан. Бизнес EXCEL 1.0 сургалтад 8, Power Bi Dashboard сургалтад-1, Tableau Dashboard сургалтад 1 албан хаагч хамрагдсан. 1. Сургалтын үр дүнд байгууллагын 2023 он гүйцэтгэсэн аудитын статистик мэдээллийг дашбоард хэлбэрээр бэлтгэн олон нийтэд мэдээлсэн. 2. Tableau Dashboard программыг ашиглан газрын дарга, тэргүүлэх аудитор Санхүүгийн тайлангийн аудитын систем FAS-ын мэдээллээс 2023 онд гүйцэтгэсэн СТА-ын шийдвэрийн хэрэгжилтийг аудитор бүрээр гарган хяналт тавин ажилласан.

- “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх” сэдвийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Прокурор, Тагнуулын байгууллагаас сургалт авснаар албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн.
- Монгол бичгийн сургалтад бүх албан хаагчид хамрагдсан ба анхан шатны сургалтад 6, дунд шатны сургалтад 3 албан хаагч хамрагдсан. Аймгийн Засаг даргын А/274 дүгээр захирамжаар “Үндэсний бичгийн олимпиад”-д аудитор Б.Нарангэрэл оролцон тусгай байр эзэлсэн.

Мэдээлэл сурталчилгаа

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, үр дүнгийн талаар ахлах аудитор Б.Должмаа орон нутгийн телевизэд ярилцлага өгч, тус ярилцлагыг ҮАГ-т хүргүүлснээр TV-9 телевиз, Toim.mn сайтаар мэдээлэл түгээсэн байна.

Тайланг Санхүүгийн аудитын дэлгэрэнгүй болон хураангуй 137 тайлан, гүйцэтгэл, нийцлийн 7 аудитын дэлгэрэнгүй болон хураангуй тайлан, инфографикийг open.audit.mn цахим сайтад, гүйцэтгэлийн 3 тайланг Визуал хэлбэрээр олон нийтийн сүлжээн дэх “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар” гэсэн пейж хуудсандаа тус тус байршуулсан. Аудитын цаг үеийн асуудлаар олон нийтийн сүлжээгээр 55 мэдээллийг түгээж 542 хандалт авсан.

Орон нутгийн нөхөн сонгуультай холбоотой 3 тайлан, дүгнэлтийг хуулийн хугацаанд audit.mn цахим хуудаст нийтэлж олон нийтэд ил тод мэдээлсэн.

Өнөөгийн Баянхонгор сонинд Баянхонгор аймгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн”-гийн талаарх мэдээлэл, тайлант онд хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын талаарх товч мэдээллийг тухай бүр нийтлүүлсэн.

Өргөдөл, гомдол

ТАГ-т 2023 онд гаднын шалгагдагч байгууллага болон иргэдээс 13, байгууллагын албан хаагчдаас 7 нийт 21 өргөдөл ирүүлснийг 20 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, дэмжлэг хүссэн 1 өргөдлийг ҮАГ-т албан бичгээр хүргүүлсэн.

Нууцтай холбоотой 2 өргөдлийг нууцын ажилтан бүртгэж, 19 өргөдлийг Able.audit.mn программд бүртгэсэн.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2023 оны 1-р улирлын мэдээг 2023.04.03-ны өдрийн 1/250, 2-р улирлын мэдээг 2023.06.30-ны өдрийн 1/382, 3-р улирлын мэдээг 2023.10.03-ны өдрийн 1/471 дүгээр албан бичгээр хүргүүлж ажиллалаа.

Дэвшүүлсэн зорилтын биелэлт

МУЕА-ын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/05 дугаар “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах” тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилтыг дэвшүүлсэн.

ТАБ-аас 2023 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөнд 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусган, дарга, тэргүүлэх аудитораар 2023.02.01-ний өдөр баталж, ҮАГ-аас дэвшүүлсэн зорилтын хүрээнд баталсан төлөвлөгөөний дагуу дэд төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилтийг ханган ажилласан тайланг TEAMS программын “ТАБ-зорилт-2023 А/07 тушаал-Ажлын хэсэг” группийн “ҮАГ-АНТАГ” хэсэгт excel файлаар байршуулсан.

Тус газрын 3 жилийн үлдэгдэлтэй 28.6 сая төгрөгийн зөрчлийг бүрэн барагдуулж, 2023 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 26,370.6 сая төгрөгийн шийдвэрээс 23,333.1 сая төгрөг хэрэгжсэн бөгөөд хугацаа болоогүй 1,422.6 сая төгрөгийг оруулан тооцоход 97.5 хувьтай болж өмнөх оноос 3.7 %-иар өссөн.

Жилийн зорилтын хүрээнд "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцох бодлого, арга зүй" сэдэвт хэлэлцүүлэгт 2023.05.26-ны өдөр цахимаар оролцож саналаа тусгаж, Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд ашиглаж байгаа Санхүүгийн аудитын систем /FAS/ программыг сайжруулах 24 саналыг YAГ-ын АНУЗГ-ат 2023.06.14-ны өдрийн 1/337 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Үндэсний аудитын газрын Тамгын даргын 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод хариуцлагатай байдлыг сайжруулах нь" сэдэвт илтгэлийн уралдаанд "Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаан, үр дагаврыг үнэлэх нь" сэдвээр илтгэлд хамтран оролцож. YAГ-ын ХБТГ-т 2023.06.19-ны өдрийн 1/353 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Аудитын үр өгөөж

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/82 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Аудитын үр өгөөжийн журам"-ын дагуу тайлант онд гүйцэтгэсэн нотлох аудитаас 8,993.8 сая төгрөгийн 258, шууд тайлагнах аудитаас 17.092.0 сая төгрөгийн 21 санхүүгийн, нийтдээ 26,085.8 сая төгрөгийн 289 санхүүгийн, 10 санхүүгийн бус үр өгөөжийг тооцсоныг орон нутгийн захиргааны болон холбогдох байгууллагууд хүлээн зөвшөөрсөн.

Тайлант онд 615.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж 505.5 сая төгрөгийг зарцуулж зардлын 1 төгрөг тутмаас 51.60 төгрөгийн үр өгөөж гарсан өмнөх онд 47.24 төгрөг байсан бөгөөд үүнээс 9.2 хувиар буюу 4.36 төгрөгөөр нэмэгдүүлэн ажиллаж тайланд жилийн зорилтыг бүрэн хэрэгжүүллээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах" зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг онцлон хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаа чиглүүлэн төлөвлөж биелэлтийг бүрэн хангаж ажиллалаа. Үүнд:



ТАГ-аас 2019-2022 оны хийсэн аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийн судалгааг гаргаж хэрэгжилтийг хангах

Тус газрын 3 жилийн үлдэгдэлтэй байгаа шийдвэрийн хэрэгжилтийн судалгаагаар 28.6 сая төгрөгийн хэрэгжээгүй шийдвэрийг хариуцлага тал болон АЗДТГ-ын хамтын ажиллагаагаар бүрэн барагдуулж (23.1 сая төгрөгийн албан шаардлага, 5.5 сая төгрөгийн төлбөрийн акт) аудитын шийдвэр 100.0 % хэрэгжсэн



Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг хангах аян зохион байгуулж гарсан үр дүнгийн талаар харилцагч талуудтай сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх байдлаар хэлэлцүүлэг зохион байгуулах

Баянхонгор аймгийн төрийн болон орон нутгийн төсөвт байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгийн танилцуулгыг орон нутаг, эрүүл мэнд, боловсролын салбарын удирдлагуудад танилцуулан хэлэлцүүлгийг зохион байгуулж шийдвэрийн хэрэгжилтийг хангах аяны хүрээнд Аймгийн Засаг даргын 2023.04.20-ны А/209 тоот захирамжаар аймгийн СТСХ, СХАА-тай хамтран "Нягтлан бодох бүртгэлийн аймгийн үзлэг"-ийг зохион байгуулав.



Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөөг инфографик болон бусад хэлбэрээр улирал бүр цахим хуудсаар, хагас бүтэн жилээр орон нутгийн хэвлэлээр нийтэд мэдээлэх

Төсвийн байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэр, гүйцэтгэлийн аудитын 4 тайланг инфографик, 3 тайланг визуал хэлбэрээр олон нийтийн цахим пейж хуудсанд байршуулсан, аудитын 4 мэдээг “Өнөөгийн Баянхонгор” сонинд нийтлүүлэн нийтэд мэдээллээ. 2023 оны шийдвэрийн хэрэгжилтийг улирал бүр Дашбоард хэлбэрээр дээрх сувгуудаар нийтэд ил тод мэдээлж хэрэгжилтийг тооцон ажилласнаар аудитын шийдвэр 97,5 %-иар биелэв.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 стратеги зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан Монгол улсын ерөнхий аудитораар 2023.01.13-нд батлуулан ажиллахын зэрэгцээ дараах дэд төлөвлөгөөнүүдийг дотоодоо батлан хэрэгжилтийг бүрэн хангаж ҮАГ-ын ЗББН-үүдэд тайланг хүргүүлэн ажиллав.

	Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөө		Харилцагч талуудын оролцооны дэд төлөвлөгөө
	Байгууллагын баримт бичиг, нягтлан шалгах комисс болон өмч хамгаалах салбар зөвлөлийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөө		Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги"-ын 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөө
	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө		

Дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт:Төрийн аудитын байгууллагын 2023 оны “Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах” зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар ажлын дэд төлөвлөгөө боловсруулан дараах 6 арга хэмжээг тусгасан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд:

1. ТАГ-аас 2019-2022 оны хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудит болон Төрийн орон нутгийн өмчит компанийн санхүүгийн аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг аудитын төрөл тус бүрээр судалгааг гарган нэгтгэж АНУЗГ-т хүргүүлэх:

ТАГ-аас 2019-2022 онд хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудит болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн тайлангийн аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг аудитын төрөл тус бүрээр судалгааг Статистик мэдээний Local.audit.mn системд оруулсан мэдээллээс авч гаргаж, нэгтгэлээр 2023.03.25-ны өдөр удирдлагад танилцуулан ҮАГ-ын АНУЗГ-т хүргүүлсэн.

Тус газрын 3 жилийн үлдэгдэлтэй 28.6 сая төгрөгийн зөрчлийг бүрэн барагдуулж, 2023 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 26,370.6 сая төгрөгийн шийдвэрээс 23,333.1 сая төгрөг хэрэгжсэн бөгөөд хугацаа болоогүй 1,422.6 сая төгрөгийг оруулан тооцоход 97.5 хувьтай болж өмнөх оноос 3.7 %-иар өссөн.

2. Төсвийн захирагчдын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар өмнөх оны зөрчил давтагдсан эсэхэд дүн шинжилгээ хийж хариуцлагатай байдлыг сайжруулах талаар зохих арга хэмжээг авах:

Баянхонгор аймгийн ТЕЗ, ТТЗ, ТШЗ нарын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитын үр дүн, зөрчлийн нэгтгэлийг аймгийн Засаг дарга болон БШУГ, ЭМГ, Соёлын газарт хүргүүлэн салбарын удирдлага, нягтлан бодогч нарт танхимаар, сумдын төсөвт байгууллагуудад суманд нь очиж танилцуулан хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллав.

Тус хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн төсвийн захирагчдын 2022 оны жилийн эцсийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийх жил бүр давтагдан гарч байгаа алдаа зөрчлийг бууруулах, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор аймгийн СТСХ, СХАА-тай хамтарсан ажлыг хэсгийг Аймгийн Засаг даргын 2023.04.20-ны А/209 тоот захирамжаар байгуулан "Нягтлан бодох бүртгэлийн аймгийн үзлэг"-ийг зохион байгууллаа.



Зураг №1. Баацагаан сумын нээлттэй хаалганы өдөрлөгөөр

Энэ ажлын хүрээнд Аймаг төв болон Баацагаан суманд “Аудитын чанар хяналтын үр нөлөөг сайжруулах” зорилтын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж ТАБ-ын цахим сайтуудыг сурталчилж, төсөвт байгууллагуудын албан хаагчдад Төрийн аудитын хууль, Төсвийн тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт, Нөлөөллийн мэдүүлгийг танилцуулж шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллав. Тус арга хэмжээнүүдийн үр дүнг 2023.12.15-нд аймгийн Засаг даргын зөвлөлд тайлагнахаар газрууд дүгнэлтэй нэгтгэн ажиллаж байна.

3. FAS системээр санхүүгийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн гаргахад Төсвийн захирагч болон нягтлан бодогч нарт сургалт хийж цахим системийн ашиглалтыг сайжруулан цаашид хөгжүүлэх санал боловсруулах:

ҮАГ-ын МТТ-өөс хэрэгжүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянах өөрчлөлтийг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэх зорилгоор Төсвийн захирагч нарт сургалт цахим хийж хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Тус Төрийн аудитын газраас Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд ашиглаж байгаа Санхүүгийн аудитын систем /FAS/ программыг сайжруулах нийт 24 саналыг ҮАГ-ын АНУЗГ-т хүргүүлэн МТТ-тэй нягт хамтран ажиллаж хэрэгжүүлсэн.

СТАС-тэй холбогдох саналыг тухай бүр нь аудиторуд хүргүүлэн засварлуулж хамтран ажиллаж цахим системийн ашиглалтыг сайжруулан хөгжүүлэлт хийлгэж, аудитын хуваарь оруулах, аудитыг гүйцэтгэх, шийдвэрийн хэрэгжилт хянах, статистик мэдээ гаргахад нэгтгэл файлуудыг бүрэн ашиглаж байна.

4. Төрийн аудитын байгууллагын 3-аас дээш жилээр хугацаа хэтэрсэн аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж, баталгаажуулах:

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 23.1 сая төгрөгийн албан шаардлага, илүү санхүүжилттэй холбоотой төлбөрийн актын 5.5 сая төгрөгийг бүрэн барагдуулж шийдвэрийг 100% хэрэгжүүллээ. Дээрх 3 жилийн үлдэгдэлтэй шийдвэрийн хэрэгжилтийн судалгаанд орсон аудитын шийдвэрийг жил бүр тодорхой хэмжээгээр биелэлтийг хангаж ажилласны дүнд 2023 онд хэрэгжилтийг бүрэн хангасан.

5. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг хангах аян зохион байгуулж гарсан үр дүнгийн талаар харилцагч талуудтай сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх байдлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

Аудитын шийдвэрийн биелэлтийг хангах аяны хүрээнд Баянхонгор аймгийн төвийн нягтлан бодогч нарт сургалт хийж, төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын үр дүн, зөрчлийн нэгтгэлийн аймгийн БШУГ, ЭМГ, Соёлын газарт хүргүүлэн шийдвэрийн хэрэгжилтэд хамтран ажиллахыг аяны хүрээнд хэрэгжилтийг 8-9 сард хянаж ажиллав.

Харилцагч талуудад сургалт, мэдээлэл зөвлөгөө өгөх ажлын хүрээнд СТСХ-тэй хамтран төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын дунд алдаа зөрчлийг бууруулах, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор баг болгон хооронд нь тэмцээн зохион байгуулсан.



Зураг № 2. Тэмцээнд оролцогчид

Баянхонгор аймгийн сумдын төсөвт газруудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж, шийдвэрийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын FAS-д оруулсан байдалд хяналт тавьж газар дээр нь зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн арга зүйгээр ханган 2023.06.05-2023.06.13-ны хооронд гурван чиглэлд 19 суманд 5 ажилтан томилолтоор ажилласны үр дүнд хэрэгжилтийг СТАС (FAS)-ээр хяналтыг хийсэн.

“Дижитал Баянхонгор-2023” өдөрлөгийг 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд болон 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдрөөр Санхүүгийн тайлангийн аудитын систем (Fas)-ийн шийдвэрийн хэрэгжилтийн байдлын талаар нэгтгэлийг Дашбоардийг excel программ ашиглан хийсэн файлаар байгууллага бүрээр харах боломжийг бүрдүүлэн цахимд байршуулан мэдээлж, шийдвэрийн хэрэгжилтийг СТА-ын систем FAS-д мэдээлэл оруулах, түүнийг хянах талаар сургалт зааварчилгааг танхимаар болон цахимаар нээлттэй сургалтыг хийв.




Зураг № 3. “Дижитал Баянхонгор-2023” өдөрлөгийн үеэр

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-тэй хамтран Баацагаан суманд 2023.09.28-ны өдөр ТАБ-ын цахим сайтуудыг сурталчилж, төсөвт байгууллагуудын албан хаагчдад Төрийн аудитын хууль, Төсвийн тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт, Нөлөөллийн мэдүүлгийг танилцуулж шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд шийдвэрийн биелэлт 97.5 хувьтай гарч жилийн дэвшүүлсэн зорилтын биелэлт хангагдлаа.

6. Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөөг инфографик болон бусад хэлбэрээр улирал бүр цахим хуудсаар, хагас бүтэн жилээр орон нутгийн хэвлэлээр нийтэд мэдээлэх

Тус газар нь төсвийн байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэр, гүйцэтгэлийн 6 аудитын тайланг инфографик хэлбэрээр бэлтгэн цахим болон олон нийтийн сүлжээнд байршуулж иргэдэд ил тод мэдээлсэн. .

2023 оны улирал бүр шийдвэрийн хэрэгжилтийг өссөн дүнгээр Дашбоард хэлбэрээр олон нийтэд түгээж ил тод мэдээлснээр иргэдэд мэдээлэл нээлттэй болж хэрэгжилтийг хангахад түлхэц болсон. Шууд тайлагнах аудитын 6 тайланг визуал хэлбэрээр олон нийтийн цахим пейж хуудсанд тус тус байршуулан нийтэд мэдээллээ.



Зураг № 4. Инфографик, дашибард хэлбэрийн мэдээллүүд

Санхүүгийн аудитын дүнгийн талаарх мэдээлэл болон шууд тайлагнах 4 аудитын мэдээллийг "Өнөөгийн Баянхонгор" сонин хэвлүүлсэн. Орон нутагт зохион байгуулсан нөхөн болон дахин сонгуультай холбоотой 4 сэдвийн хүрээнд хийсэн аудитыг хуулийн дагуу хугацаанд нь гүйцэтгэж холбогдох мэдээллийг олон нийтэд хугацаанд нь байгууллагын цахим хуудаст байршуулж иргэдэд ил тод мэдээлж ажилласан.


Хүний нөөц: Тайлант онд нийт хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, дүрэм журмыг мөрдөн ажиллав.



Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 12 орон тоогоор ажиллахаас 10 орон тоогоор 11 сар хүртэл ажиллаж Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул аудиторын 2 орон тоог нөхөж 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс батлагдсан 12 орон тоогоор ажиллаж байна

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2023 оны гүйцэтгэлийн зорилтод ажлаа үндсэн 12 ажилтантайгаар 21384 хүн/цаг ажиллахаас 21248 хүн/цаг буюу 1651 хүн/цаг илүү ажиллан дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэв.

Бүтэц, зохион байгуулалт: Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/02 тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.



Нотлох аудитад 2 аудитор, шууд тайлагнах аудитад 7 аудитор, ажлын ачааллаас шалтгаалан шууд тайлагнах аудитын аудиторууд хоорондоо шилжин ажиллах нь хэвээрээ байхаар зохион байгуулалтыг хийж ажиллалаа.



Тус аудитын газар нь 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, МУЕА-аас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжүүлэхэд өдөр тутмын ажлаа чиглүүлэн Удирдлагын ABLE системийн “АЖИЛ ХЭРЭГ” цэсийг ашиглан 7 хоногоор хийх ажлын төлөвлөгөө болон үүрэг даалгаврын биелэлтэд нийт ажилтны шуурхай хурлаар хэлэлцэх байдлаар хяналт тавин удирдан зохион байгуулж ажилласан. Тайлант хугацааны дүнгээр нийт 86 ажлыг өдөр тутам нэмж гүйцэтгэхээр ABLE системийн ажил хэрэг цэсэд оруулж хэрэгжилтийг хангасан байна.

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ





Аудитын дүгнэлт
ӨӨРЧЛӨЛТГҮЙ 120
ХЯЗГААРЛАЛТТАЙ 17



Шийдвэрийн хэрэгжилт

97.5%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН !!!

ХУГАЦАА БОЛООГУЙ ШИЙДВЭРИЙГ ХАСАЖ ТООЦОХОД

Тайлант 2022 онд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.8-д заасан хугацаанд нийт 269 байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийснээс 132 байгууллагад түүвэр, 137 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргаж, үүнээс 120 байгууллага “Өөрчлөлтгүй”, 17 байгууллагад “Хязгаарлалттай”, санал дүгнэлт гаргасан байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар бодлогоор гүйцэтгэлийн 3, нийцлийн 1 аудит, хуулийн дагуу гүйцэтгэлийн 2, нийцлийн аудит 4 нийтдээ шууд тайлагнах 10, үүнээс гүйцэтгэлийн 5 аудит, нийцлийн аудит 5-ыг тус тус гүйцэтгэж, тайлан, судалгааг хугацаанд нь холбогдох газруудад албан тоотор хүргүүлсэн.

2023 онд гүйцэтгэсэн санхүү, гүйцэтгэл болон нийцлийн аудитаар нийт 26,220.6 сая төгрөг алдаа, зөрчил илэрснээс 2,481.9 сая төгрөгийн 106 алдааг санхүүгийн тайланд залруулж, 23,738.7 сая төгрөгийн 846 зөрчил илэрснээс 748.7 сая төгрөгийн 187 төлбөрийн акт тогтоосноос 711.9 сая (95.1%), зөрчлийг арилгах 14,877.4 сая төгрөгийн 206 албан шаардлага хүргүүлснээс 12,929.3 сая (86.92%), зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 7,480.9 сая төгрөгийн 434 заалт бүхий зөвлөмж өгснөөс 6,428.3 сая (85.9%) төгрөгийн зөрчлийг арилгаж, сахилгын шийтгэл ногдуулах 618.8 сая төгрөгийн 16 албан шаардлагыг хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж хууль хяналтын байгууллагад 12.9 сая төгрөгийн 2 зөрчил, өмнөх оны хэрэгжээгүй 150.0 сая төгрөгийн 1 албан шаардлагыг шилжүүлж шалгуулсан. Нийт шийдвэрийн хэрэгжилтийн дундаж хувь 94.7 хувьтай байгаа нь 1,422.6 сая төгрөгийн 21 шийдвэрийн хэрэгжилт тооцох хугацаа болоогүйтэй холбоотой байна. Хугацаа болоогүй шийдвэрийн хэрэгжилтийг хасаж тооцвол төлбөрийн актын 96.1%, албан шаардлагын 89.6%, зөвлөмжийн 99.4%, дунджаар 97.5% биелэлттэй гарч байна.

Тайлант онд нийт 26,085.8 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж, үйл ажиллагааны зардалд 505.0 сая төгрөгийг ХБГ-ээр зарцуулж зардлын 1 төгрөг тутмаас 51.60 төгрөгийн үр өгөөж гаргасан. Тайлант оны үр өгөөжийг өмнөх оноос 9,2 хувиар буюу 4.36 төгрөгөөр нэмэгдүүлэн ажиллалаа.

Аудитаар хууль, тогтоомж зөрчсөн буруутай 16 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж биелэлтийг хангуулсан.


2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 3,037.5 сая төгрөгийн 39 шийдвэр үлдэгдэлтэй гарснаас 1,422,6 сая төгрөгийн 21 шийдвэрийн хэрэгжилтийн хугацаа болоогүй, 1,614.9 сая төгрөгийн 18 шийдвэр хугацаа хэтэрсэн дүнтэй байна.

Төлбөрийн актын 96.1%, албан шаардлагын 89.6%, зөвлөмжийн 99.4% биелэлттэй хэрэгжсэн байна.

Шийдвэрийн хэрэгжилт

Албан шаардлага

- 14,877.4 сая төгрөгийн 206 ширхэг албан шаардлага хүргүүлсэн
- 12,929.3 сая төгрөгийн төлбөрийн акт барагдуулсан



Төлбөрийн акт

- 748.7 сая төгрөгийн 187 ширхэг төлбөрийн акт тогтоосон
- 711.9 сая төгрөгийн төлбөрийн акт барагдуулсан

Зөвлөмж

- 7,480.9 сая төгрөгийн 434 ширхэг зөвлөмж өгсөн
- 6,428.3 сая төгрөгийн төлбөрийн акт барагдуулсан

Сахилгын шийтгэл

- 618.8 сая төгрөгийн 16 албан шаардлагыг бүрэн биелүүлсэн.

Аудитын залруулга

- 2,481.9 сая төгрөгийн 106 алдааг санхүүгийн тайланд залруулсан

Хууль хяналтын байгууллагад

- 162.9 сая төгрөгийн 3 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дахь заалтын хэрэгжилт:



Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалтын дагуу 6 зөрчлийн 15,5 сая төгрөгийн албан шаардлагыг 2023.07.06-ны өдрийн 2/384 тоот албан бичгээр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд хүргүүлсэн. Үүнээс Цэвэр хот ОНӨААТҮГ-ын захирал Ц.Баясгалан нь 2023.06.30-ны өдөр 1.3 сая төгрөгийг байгууллагын дансанд шилжүүлж бүрэн хангасан. Мөн Баянхонгор сумын Засаг Дарга асан Ц.Насанбаяр нь 2022 онд нас барсан тул албан шаардлагыг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.

Аймгийн Прокурорын газартай Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, төрийн төлөөлүүлж шүүхэд нэхэмжлэл гаргуулах талаар хамтран ажиллах санаамж бичгийг 2023.06.15-нд байгуулан хамтран ажиллав.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН АУДИТ

Дүгнэлт 132
Түүвэрт
хамруулсан 137

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8-д заасан аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 123 байгууллага (49 төсвийн байгууллага, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч), төсвийн ерөнхийлөн захирагч 1, улсын төсвийн 30, боловсролын салбарын 70, эрүүл мэндийн байгууллагын 23, соёлын байгууллын 22 нийт 269 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулсан.



Аудитад хамрагдсан байгууллагуудаас 137 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 132 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан бөгөөд 120 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 17 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.



Санхүүгийн тайлангийн аудитын 85.1 хувийг буюу 229 байгууллагыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар өөрсдийн хүчээр гүйцэтгэж, 14.9 хувь буюу 40 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг “Номгон аудит” ХХК 20 байгууллагад, “Глобал капитал аудит” ХХК компани 20 байгууллагатай гэрээ байгуулж, аудитыг гүйцэтгэсэн байна.



Аудитад Төрийн аудитын байгууллагын үндсэн 9 аудитор, хараат бус аудитын 2 компанийн 6 аудитор гүйцэтгэн, үе шатны хяналтыг аудитын менежер хяналт тавьж, газрын дарга, тэргүүлэх аудитор хянан удирдан 219.9 сая төгрөгийн өртгөөр нийт 15 хүн 936 хүн/өдөр, 1133 илүү цаг ажиллан 8,993.8 сая төгрөгийн 258 санхүүгийн үр өгөөж хүлээн зөвшөөрөн ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн:

- Санхүүгийн тайлангийн аудитаар 2,481.9 сая төгрөгийн 106 алдаа илэрч санхүүгийн тайланд залруулсан.
- Аудитаар нийт 8,972.7 сая төгрөгийн 760 зөрчил илрүүлснээс 733.8 сая төгрөгийн 185 төлбөрийн акт тогтоож, 2,886.1 сая төгрөгийн 181 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 5,057.1 сая төгрөгийн 382 зөвлөмж хүргүүлж, 12 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 295.7 сая төгрөгийн албан шаардлагыг хүргүүлж ажиллав.
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,723.3 сая төгрөгийн алдаа зөрчил илүүлснээс 13.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 525.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан өгч, 1,184.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 8 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй 260.9 сая төгрөгийн 69 зөрчил илэрснээс 16.9 сая төгрөгийн 25 төлбөрийн акт, 98.2 сая төгрөгийн 19 албан шаардлага, 145.8 сая төгрөгийн 25 зөвлөмжийг хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хамтатган хэрэгжүүлж 269 байгууллагыг шалгаж мэдээллийг FAS системийн Шилэн данс цэст оруулсан. Шилэн дансны сайтад 17890 шийдвэрийн 375,183.6 сая төгрөгийн мэдээллийг байршуулахаас 15,082.2 сая төгрөгийн 990 мэдээллийг мэдээлээгүй, 10,864.5 сая төгрөгийн 442 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрч зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 79 зөвлөмж, 46 албан шаардлага хүргүүлэн ажилласан.
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжээгүй үлдэгдэлтэй байсан 76.3 сая төгрөгийн 10 төлбөрийн актаас 52.6 сая төгрөгийн 8 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 163.4 сая төгрөгийн 17 албан шаардлагаас 94.5 сая төгрөгийн 6 албан шаардлагын зөрчлийг арилгаж, 12.2 сая төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн актын 96 хувь буюу 705.5 сая, албан шаардлагын 94% буюу 2,703.0 сая төгрөгийг барагдуулж, зөвлөмжийн 99 хувь буюу 5,013.5 сая төгрөгийн хэрэгжилтийг шалгагдагч байгууллага гаргаж ирүүлснийг нотлох баримтад үндэслэн тооцов. Нийт шийдвэрийн 96 хувийг хэрэгжүүлэн ажилласан.

Ерөнхий чиглэлийн хэрэгжилт



Аудитыг Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналд тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”, Ерөнхий аудиторын орлогчийн баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийг баримтлан төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийх санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт тусган эрсдэлтэй асуудалд анхаарлаа хандуулан алдаа зөрчлийг илрүүлж, ерөнхий чиглэлийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг 2023.06.30-ны өдрийн 1/381 дугаар албан бичгээр ҮАГ-ын АНУЗГ-т хүргүүлэн ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитын онцлог



1. Санхүүгийн тайлангийн аудитыг “Санхүүгийн тайлангийн аудитын систем FAS” ашиглан аудитын бүх үе шатны ажилбарыг гүйцэтгэн санхүүгийн тайлангийн аудитын статистик мэдээний үндсэн бааз суурь бий болсон.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг шинээр дагаж мөрдсөн тайлант хугацаанд аудит хийж үр дүнг FAS системээр нэгтгэсэн.



3. Санхүүгийн тайлангийн аудитын системээр шалгагдагч байгууллагаас нэгдсэн судалгааг цахимаар нэгтгэсэн, мөн СТА-аар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг шалгагдагч байгууллагын зүгээс цахимаар бэлтгэн аудиторуд хянан баталгаажуулсан үйл ажиллагаа нь аудитад хамрагдагч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлсэн, аудиторын ажлыг хөнгөвчилсэн, хэрэгжилтийн нотлох баримтын цахим сан үүсгэсэн дэвшилтэт алхам болов.

Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө



Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар 210 байгууллагад нийт 714.6 сая төгрөгийн төсвийг хэмнэж, тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны орлого 211.6 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрч санхүүгийн үр өгөөж хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

- Баянхонгор сум: Засаг даргын 2022 онд төсвийн зардлын хэмжээг 1,157.0 сая төгрөгөөр нийт зардлыг бууруулан баталж, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 328.8 сая төгрөгийг хасаж гүйцэтгэлээр 713.6 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн.

- Баян-Овоо сум: Засаг даргын 2022 оны төсвийн зардлыг 293.4 сая төгрөгөөр бууруулж аймгийн төсөвт 241.4 сая төгрөг төвлөрүүлсэн.

- Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраас уралдаант сонгон шалгаруулалтаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Хонгор 1000” дулаан үйлдвэрлэлийн барилга байгууламжийг 2,032.0 сая, “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т ашиглаж байсан явган замын хавтан үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг 385.3 сая төгрөгөөр хувьчилснаар орон нутгийн хөрөнгийг эргэлтэд оруулж 2,317.3 сая төгрөгийн үр нөлөө гарсан.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалт, их засварын ажлыг Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.02.13-ны өдрийн 13/11 тогтоол "Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" тогтоолоор 4,103.8 сая төгрөгийн хөрөнгийг эзэмшигч тогтоох шийдвэр гарч ашиглагч байгууллагад үндсэн хөрөнгөөр бүртгэснээс үр өгөөжөөр хүлээн зөвшөөрсөн.

Завсрын аудитын талаар:

МУЕА-ын 2023.08.01-ны өдрийн А/75 дугаар "Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" тушаалаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь 2023-2024 онд 265 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргах болон үе шатны ажлыг хэсэгчлэн хийхээр баталсан.

Санхүүгийн тайлангийн 2023 оны завсрын аудитын төлөвлөгөөг МУЕА-ын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг даргын баталсан "Төсвийн захирагчдын 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын үеийн аудит хийх удирдамж" -ийг чиглэл болгон 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр газрын дарга, тэргүүлэх аудиторар батлуулсан. Санхүүгийн тайлангийн FAS системд түүвэрт хамруулсан болон дүгнэлт өгөх байгууллагуудын төлөвлөлтийн шатны ажлыг гүйцэтгэсэн.

Завсар үеийн аудитаар ТШЗ-ийн санал дүгнэлт өгөх 76 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит 2 аж ахуйн нэгж, түүвэрт хамруулах 45 байгууллага нийт 123 байгууллагын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, аудитын ерөнхий чиглэлийг хэрэгжилтийг хэсэгчлэн шалгаж, Баянхонгор аймгийн ЗДТГ, Нэгдэн эмнэлэг, аймгийн Онцгой байдлын газар, Сум дундын ойн анги, Жинст, Богд, Баянговь, Шаргалжуут, Баацагаан сумдын төсөвт байгууллагуудын төлөвлөлтийн үе шатны ажлыг FAS-д оруулан, асуудлын бүртгэлийг хянуулан ажилласан.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай СТА-ыг гэрээгээр гүйцэтгэх аудитын Хуулийг этгээд 30 байгууллагын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



Тайлант оны эхний хагас жилд УАГ-ын нэгдсэн удирдамжаар бодлогын 3, хуулийн дагуу гүйцэтгэх 2, нийт 5 гүйцэтгэлийн аудитыг 20 хүн 128 өдөр 420 цаг илүү ажиллан гүйцэтгэн, нийт 13,262.1 сая төгрөгийн 69 зөрчил илэрсэнд 3.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 10,511.4 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага хүргүүлж, холбогдох албан тушаалтнуудад 2,423.8 сая төгрөгийн 42 зөвлөмж хүргүүлэн, албан үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах 4 албан шаардлагыг хүргүүллээ.

Нийт 13,262.1 сая төгрөгийн 69 зөрчил



“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд”-д хийсэн аудит

УАГ-ын нэгдсэн удирдамжаар аудитыг 4 аудитор 23 өдөр, 54 хүн/өдөр, 130 илүү цаг ажиллан 52 байгууллагыг хамруулан шалгаж, АДБОУС, MNS 6817-7:2020 стандартын дагуу гүйцэтгэн дүнг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, Газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.04.20-ны өдрийн А/08 тоот тушаалаар тушаалаар баталгаажуулсан.

Аудитын тайланг 2023.04.20-ны өдөр 1/286 тоот албан бичгээр ҮАГ-ын ГНАГ-т, 1/287 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Засаг даргад, 1/288 тоот албан бичгээр аймгийн ИТХ-д, 1/289 тоот албан бичгээр ҮАБЗ-д тус тус хүргүүлэн байгууллагын цахим хуудаст тайланг байршуулан олон нийтэд хүргэсэн.

- Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байгаа ба санхүүгийн 366.6 сая төгрөгийн 2, санхүүгийн бус 1 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн ажилласан. Аудитаар өгсөн зөвлөмжийг 100 хувь бүрэн биелүүлсэн бол 736.5 сая төгрөгийн 9 албан шаардлагын биелэлтийг хангаж 1,359.0 сая төгрөгийн 2 албан шаардлагыг биелэлтийг хангаагүйгээс албан шаардлагын биелэлт 35.1 хувьтай байна. Албан шаардлага биелээгүй шалтгаан нь Баянхонгор сумд баригдсан 280 хүүхдийн цэцэрлэгийн барилын нэмэгдэл санхүүжилт авсан ажил бүрэн хийгээгүйгээс хэрэгжилт дутуу байгаа нь гол нөлөө үзүүлж байна.
- Аудитын тайланг 2023.04.20-ны өдөр 1/286 тоот албан бичгээр ҮАГ-ын ГНАГ-т, 1/287 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Засаг даргад, 1/288 тоот албан бичгээр аймгийн ИТХ-д, 1/289 тоот албан бичгээр ҮАБЗ-д тус тус хүргүүлэн байгууллагын цахим хуудаст тайланг байршуулан олон нийтэд хүргэсэн.

Аудитын үр нөлөө

- Зураг төсөвт магадлал хийгдээгүй ажил эхлүүлснээс шалтгаалан дутуу гүйцэтгэсэн 280 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын дутуу ажлыг гүйцэтгүүлэх хугацаатай албан шаардлага өгсөн.
- Зураг төсвийн дагуу хийгээгүй зарим ажлыг дахин гүйцэтгүүлснээс гадна, ашиглалтын явцад шаардлага хангаагүй 4 төсөл, арга хэмжээнд зөрчлийг арилгах албан шаардлага өгч биелэлтийг хангуулсан.
- Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн тоног төхөөрөмжийг хүлээн авч хуваарилахдаа аймгийн төвийн сургуулиудад хуваарилсан байсныг албан шаардлага өгч малчдын хүүхдийг дэмжих гол зорилгод нийцүүлэхээр албан шаардлага өгч биелэлтийг хангуулсан.
- Хөрөнгө оруулалтаар хийсэн 349.9 сая төгрөгийн хөрөнгийг эзэмшүүлэх шийдвэр гаргаагүй байсанд албан шаардлага өгч хөрөнгийг бүртгүүлсэн.

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө”-д хийсэн аудит:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудитыг 2023.03.27-2023.05.19-ний хооронд хянан удирдах 2, гүйцэтгэх 2 аудитор нийт 35 өдөр 70 илүү цаг зарцуулж, шалгагдагч 5, хамрагдагч 74 байгууллагын 2021-2022 оны үйл ажиллагаанд аудит хийж Газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2023.05.19-ний өдрийн А/10 дугаар тушаалаар тайланг баталгаажуулан, албан бичгээр ҮАГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.



Гүйцэтгэлийн аудитаар нийт 301.4 сая төгрөгийн 27 зөрчил илэрсэнд ҮАГ-аар дамжуулан ЭМЯ-д нэг, ЭМДЕГ-т 10 саналыг уламжлан, нийт 23 зөвлөмж өгсний 7 нь хууль

тогтоомжийн хэрэгжилттэй, 13 нь дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 3 нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөвлөмж өгсөн байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг 2023.11.09-ний өдөр 677 дугаар албан бичгээр 87.5 хувь, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2023.11.10-ны өдөр 01/392 дугаар албан бичгээр 100 хувь, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс 2023.11.10-ны өдрийн 14/185 дугаар албан бичгээр 100 хувь, аймгийн Эрүүл мэндийн газар 2023.11.16-ны өдөр 771 дүгээр албан бичгээр 87.1 хувь, аймгийн ЗДТГ 2023.11.16-ны өдөр 6/1558 дугаар албан бичгээр 86.7 хувьтай тайлагнасныг нотлох баримттай тулган шалгахад зөвлөмжийн биелэлт нийт дүнгээр 88.8 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Аудитын үр дүнгийн талаарх инфографикийг байгууллагын фэйж хуудаст байршуулсан, мэдээллийг 2023.11.18-ны өдрийн байдлаар 14 хүний хандалт авсан байна.

Аудитын үр нөлөө

- Аудитын зөвлөмжийн биелэлтээс 0.4 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлснийг санхүүгийн үр өгөөжөөр тооцож, ЭМДЕГ-т хүргүүлсэн саналаас 2 санал үр дүнгээ өгсөн, шалгагдагч болон хамрагдагч байгууллагууд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар 9, нийт 11 санхүүгийн бус үр өгөөжийг гарсныг бүртгэж ажиллав.

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн аудит:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар аудитыг АДБОУС, MNS 6817-7:2020 стандартын дагуу 2023.05.23-ны өдрөөс 2023.08.18-ны хооронд хянан удирдах 2, гүйцэтгэх 3 аудитор 30 өдөр, 60 илүү цаг ажиллаж, аудитаар нийт 316.4 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, 1 албан шаардлагыг хүргүүлж, газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2023.08.18-ний өдрийн А/19 тоот тушаалаар гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн аудитын тайланг 2023.08.18-ны өдрийн 1/393 дугаар албан бичгээр ҮАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн газар, ИТХ-ын даргад 1/394, Монгол Улсын ҮАБЗММХ Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэгт 1/395, аймгийн Засаг даргад 1/396, аймгийн ХХААГ-т 1/397, Мал эмнэлгийн газарт 1/398 дугаар албан бичгээр хүргүүлэн ажилласан.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар 2023.11.15-ны өдөр 01/190, аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар 2023.11.17-ны өдөр 2/338 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг 2 байгууллага бүрэн хэрэгжүүлэн, хэрэгжилт 100 хувь байна.

Шинэжинст сумын ЗДТГ аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, хөрөнгийг орлогод авч, 2023.11.17-ны өдөр 157 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн тул санхүүгийн үр өгөөжөөр тооцов.

Аудитын үр дүнгийн талаарх инфографикийг байгууллагын open.audit.mn болон олон нийтийн сүлжээндэх байгууллагын пейж хуудаст байршуулж нийтэд түгээсэн. Тус мэдээллийг 2023.11.18-ны өдрийн байдлаар 16 хүний хандалт авч, 3 хүн хуваалцсан байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙЦЛИЙН АУДИТ;



Хуулийн дагуу гүйцэтгэх аудит



Тайлант онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар бодлогын 1, хуулийн дагуу гүйцэтгэх 4, нийт нийцлийн аудитыг 15 хүн 54 өдөр 98 цаг илүү ажиллан гүйцэтгэн, нийт 1,491.0 сая төгрөгийн 15 зөрчил илэрсэнд 11.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,479.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, холбогдох албан тушаалтнуудад 10 зөвлөмж хүргүүлэв.

“Орон нутгийн 2023 оны” нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн мөрийн хөтөлбөрийн тайланд дүгнэлт гаргах аудит

Аудитыг 2 аудитор 5 өдөр зарцуулан гүйцэтгэж, Монгол ардын нам, Ардчилсан намаас ирүүлсэн мөрийн хөтөлбөрт аудит хийж, аудитын дүгнэлт, мөрийн хөтөлбөрийг тухайн шатны сонгуулийн хороо, намуудад албан бичгээр хүргүүлж, аудитын дүгнэлт, хандивын тайланг байгууллагын цахим хуудаст байршуулсан.

- Сонгуульд оролцох намуудын мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг Баянхонгор аймгийн Сонгуулийн хороонд 2/266 тоот, Баян-Овоо сумын сонгуулийн хороонд 2/267 тоот, Заг сумын сонгуулийн хороонд 2/268, Баянговь сумын сонгуулийн хороонд 2/269, Богд сумын сонгуулийн хороонд 2/270 тоот албан бичгээр, Аймгийн болон Баян-Овоо, Заг, Богд сумын Монгол ардын намын хороонд 2/257, 2/258, 2/259, 2/260 тоот албан бичгүүдээр, Аймгийн болон Баян-Овоо, Заг, Богд, Баянговь сумын Ардчилсан намын хороонд 2/261, 2/262, 2/263, 2/264, 2/265 тоот балбан бичгээр тус тус 2023.04.18-ны өдөр хүргүүлсэн.
- Аудитын дүгнэлтийг цахим хуудаст сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт, намуудын мөрийн хөтөлбөрийг хуулийн хугацаанд буюу 2023.05.27-ны өдөр байршуулсан.

“Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн хандивын тайланд дүгнэлт гаргах”

Аудитыг 2 аудитор 5 өдөр зарцуулан гүйцэтгэж, Монгол ардын нам, Ардчилсан намаас ирүүлсэн хандивын тайланд аудит хийж, аудитын дүгнэлтийн тухайн шатны сонгуулийн хороо, намуудад албан бичгээр хүргүүлж, аудитын дүгнэлт, хандивын тайланг байгууллагын цахим хуудаст байршуулсан.

- Сонгуульд оролцох намуудын Хандивын тайлангийн дүгнэлтийг Баянхонгор аймгийн Сонгуулийн хороонд 2/283 тоот, Баян-Овоо сумын сонгуулийн хороонд 2/282 тоот, Заг сумын сонгуулийн хороонд 2/281, Баянговь сумын сонгуулийн хороонд 2/284, Богд сумын

сонгуулийн хороонд 2/280 тоот албан бичгээр, Аймгийн болон Баян-Овоо, Заг, Богд сумын Монгол ардын намын хороонд 2/271, 2/272, 2/273, 2/274 тоот албан бичгүүдээр, Аймгийн болон Баян-Овоо, Заг, Богд, Баянговь сумын Ардчилсан намын хороонд 2/275, 2/276, 2/277, 2/278, 2/279 тоот балбан бичгээр тус тус 2023.04.18-ны өдөр хүргүүлсэн.

- Аудитын дүгнэлтийг цахим хуудаст сонгуулийн хандивын тайланг хуулийн хугацаанд буюу 2023.05.27-ны өдөр байршуулсан.

“Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх”

Аудитыг 1 аудитор 5 өдөр зарцуулан “Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх” нийцлийн аудитыг гүйцэтгэн аудитын тайланг газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023.08.25-ны өдрийн А/21 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Сонгуулийн тайланг хуулийн хугацаанд 2023.09.16-ны өдөр байгууллагын цахим хаягт байршуулж олон нийтэд мэдээлсэн.

“Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх”

“Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг газрын дарга, тэргүүлэх аудитораар 2023.07.18-ны өдөр батлуулж 5 хүн 10 өдөр 40 тлүү цаг гүйцэтгэв.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд суурь орлого нэмэгдүүлэх саналыг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2023.10.06-ны өдрийн 1/477 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 3,245.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зарлагыг 790.0 сая төгрөгөөр бууруулах, төсвийн үр ашгийг 2,480.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, нийт 6,515.4 сая төгрөгийн санал, дүгнэлтийг аймгийн ИТХ-д 2023.11.24-ны өдрийг 1/660, Засаг даргад 2023.11.24-ны өдрийн 1/671 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Аудитаар 6,515.4 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрч бүртгэв.

 Бодлогоор гүйцэтгэх аудит

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хийсэн аудит

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн удирдамжаар аудитыг 5 хүн 29 өдөр, 101 хүн/өдөр, 58 илүү цаг ажиллан 45 байгууллагыг хамруулан шалгаж, АДБОУС, MNS 6817-7:2020 стандартын дагуу гүйцэтгэн дүнг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, Газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022.06.19-ны өдрийн А/15 тоот тушаалаар тушаалаар баталгаажуулан Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, Баянхонгор аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлсэн.

Аудитаар нийт 1,491.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 11.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1,479.9 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга, аймгийн Татварын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Бөөнцагаан Орог нуурын сав газарт нийт 8 зөвлөмж 1 төлбөрийн акт, 3 албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг тооцож ажилласан. Аудитаар тогтоосон төлбөрийн актаас 3.5 сая орж 31.5 хувь, 3 албан шаардлага 100 хувь бүрэн, 1 албан шаардлага 82.4 хувь нь биеэлж нийт албан шаардлага 87.0 хувийн биелэлттэй, 10 зөвлөмж өгсөний 6 зөвлөмжийн биелэлтийг хангаж зөвлөмжийн биелэлт 60 хувь байна. Шийдвэрийн хэрэгжилтийн бүрэн тооцох хугацаа болоогүй байна.

Аудитаар татварын орлоготой холбоотой 1,299.2 сая төгрөгийн 4 төрлийн санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэв.

Аудитын үр нөлөө

- Ангийн орлогоор өгөөшний орлого тооцоолж төвлөрүүлээгүй 11.1 сая төгрөгийн орлогод төлбөрийн акт тогтоож орон нутгийн орлого нэмэгдэх нөхцөл бүрдүүлсэн.
- Татварын ногдуулалтын 1,479.9 сая төгрөгийн татварын орлогын төвлөрүүлэлт хийгдээгүйд албан шаардлага өгснөөр татварын татварын төвлөрүүлэлт сайжирна.
- Сав газрын хэмжээнд байгалийн нөөц ашиглагчийн дүгнэлт гаргаагүй байдалд дүн шинжилгээ хийж зөрчилд албан шаардлага өгснөөр татварын бааз суурь нэмэгдэнэ.
- Хяналтын тогтолцоонд гарч болзошгүй эрсдэлийг тогтоож тогтолцооны өөрчлөлт хийснээр байгалийн нөөцийн зохистой ашиглалт бий болно.

ТАВДУГААР БҮЛЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ



Тайлант онд аймгийн ИТХ-ын захиалгаар хийх аудитыг 45.2 сая төгрөгийн өртгөөр нийт 6 хүн 35 өдөр, 140 хүн/өдөр, ажиллан гүйцэтгэсэн байна.

“Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээ, бүтээн байгуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

Аймгийн ИТХ-ын захиалгаар аудитыг АДБОУС, MNS 6817-7:2020 стандартын дагуу 2023.08.10-ны өдрөөс 2023.10.06-ны хооронд хянан удирдах 2, гүйцэтгэх 4 аудитор 35 өдөр, 160 илүү цаг ажиллаж, аудитаар нийт 9.944.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж 3.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 8.931.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, зөрчил гаргасан албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулах 3 албан шаардлага өгч, 1,009.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 11 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүл хүргүүлж, газрын дарга, Тэргүүлэх аудиторовын 2023.10.06-ний өдрийн А/27 тоот тушаалаар гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн аудитын тайланг 2023.10.06-ны өдрийн 1/505 дугаар албан бичгээр ИТХ-ын даргад, Монгол Улсын ҮАБЗММХ Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэгт 1/504, аймгийн Засаг даргад 1/506 албан бичгээр хүргүүлж, аймгийн ГХБХБГ, БОАЖГ, ОНӨГ, Баянхонгор сумын Засаг дарга, “Баянхонгор-Эрчим хүч” ХХК, “Чандмань-Баянхонгор” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК зэрэг бусад хамрагдагч нарт цахим хэлбэрээр тайланг түгээж ажилласан.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй ба 2023 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар төлбөрийн акт бүрэн биелж, 5,166.0 сая төгрөгийн 4 албан шаардлагын биелэлтийг хангаж нийт албан шаардлагын биелэлт 72.9 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан 640 хүүхдийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, хөрөнгийг орлогод авч, 2023.11.17-ны өдөр А/335 тоот албан бичгээр хариу ирүүлсэн тул санхүүгийн үр өгөөжөөр тооцов.

Аудитын үр дүнгийн талаарх инфографикийг байгууллагын open.audit.mn болон олон нийтийн сүлжээндэх байгууллагын пейж хуудаст байршуулсан. Тус мэдээллийг 2023.11.17-ны өдрийн байдлаар 17 хүний хандалт авч, 6 хүн хуваалцсан байна.

Аудитын үр нөлөө

- Шинэ суурьшлын бүсэд ажил зогсоод байсан 10 км замын ажилд захиалагчид тавих хяналтыг сайжруулах албан шаардлага өгснөөр гарсан зөрчил арилж, ажлыг үргэлжлүүлэн хийж эхэлсэн.
- Ингэний сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглалт оруулж эхлэхэд бэлэн болсон ба үйлдвэр ашиглалтад орсноор байнгын ажлын байр нэмэгдэж, орон нутгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ өснө.
- Бүтээн байгуулалтын ажлын мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх, зөвлөмжийг өгснөөр олон нийтийн хяналт бий болсон.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ

Сургалтын талаар:

Төрийн аудитын байгууллагын 2023 онд дэвшүүлсэн "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах" зорилтын ТАБ-аас болон байгууллагын дотоод сургалтаар 4 чиглэлээр 16 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулан Газрын дарга, тэргүүлэх аудитораар 2023.03.01-ны өдөр батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр тайлагнан ҮАГ-ын ХБТГ-т хүргүүлэн ажиллав.

ТАБ-ын нэгдсэн сургалтын болон байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2023 онд 6 зорилтын хүрээнд 43 удаагийн сургалт, хэлэлцүүлгээр 684 албан хаагч давхардсан тоогоор хамрагдсан.

Үүнд: - ҮАГ-аас зохион цахимаар зохион байгуулсан 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 98 албан хаагч, танхимаар зохион байгуулсан сургалтад 2 албан хаагч оролцсон. Төрийн аудитын байгууллагын 2023 оны цахим сургалт зохион байгуулах төлөвлөгөөний дагуу 7 сэдэвт сургалтад 17 албан хаагч суралцсан.

- Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 8 сургалтад давхардсан тоогоор 89 албан хаагч
- Бусад байгууллагаас зохион байгуулсан 9 сургалтад 42 албан хаагч тус тус оролцсон байна.
- ТАГ-аас харилцагч байгууллагуудад зориулсан 6 удаагийн сургалтад 416 албан тушаалтан хамрагдсан.
- Нэгжийн даргын мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 20 албан хаагч оролцлоо.
- Сургалтаар 20 гэрчилгээ шинээр авсан. Албан хаагчдын мэдлэг боловсролоо дээшлүүлэх тасралтгүй боловсролын сургалтад ММНБИ-ээс зохион байгуулсан сургалтад 7 албан хаагч, ТМЗН-ээс зохион байгуулсан сургалтад 2 албан хаагч хамрагдсан. Дотоод сургалтын 2023 оны жилийн эцсийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023.11.33-ны өдөр ҮАГ-ын ХБТГ-т хүргүүлсэн.

Онцлох сургалтууд:

- “Төрийн аудитын байгууллагын статистик мэдээг боловсруулах, тайлагнах журам”, “Аудитын чанарын хяналтын журам” болон “Аудитын чанарын баталгаажуулалтын журам”-ын танилцуулах сургалтад бүх албан хаагч хамрагдан суралцан 2023 оны эхний хагас жилийн статистик мэдээг шинэ маягтаар нэгтгэн гаргаж ҮАГ-ын АНУЗГ-т хүргүүлсэн.
- Datashool цахим сургалтад ТАГ-ын 8 албан хаагч хамрагдсан. Бизнес EXCEL 1.0 сургалтад 8, Power Bi Dashboard сургалтад-1, Tableau Dashboard сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
 1. Сургалтын үр дүнд байгууллагын 2023 он гүйцэтгэсэн аудитын статистик мэдээллийг дашбоард хэлбэрээр бэлтгэн олон нийтэд мэдээлсэн.
 2. Tableau Dashboard программыг ашиглан газрын дарга, тэргүүлэх аудитор Санхүүгийн тайлангийн аудитын систем FAS-ын мэдээллээс 2023 онд гүйцэтгэсэн СТА-ын

шийдвэрийн хэрэгжилт, Албе системээс албан хэрэг хөтлөлт, үүрэг даалгаврын хэрэгжилт, цаг ашиглалтын мэдээллийг татаж авч боловсруулалт хийж аудиторчуудын ажлын үзүүлэлтийг гарган хяналт өдөр тутмын тавин ажилласан.


- Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийн арга зүй сэдэвт цахим, танхим хосолсон сургалтад газрын дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, аудитор-нягтлан бодогч нар хамрагдан суралцан үр дүнд суурилсан 2024 оны төсвийн төсвийг бэлтгэсэн.
- "Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах" зорилтын хүрээнд аймгийн төвийн болон сумдын төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч, нярав нарт "Санхүүгийн тайлангийн 2022 оны аудитын үр дүн" сэдэвт сургалтаар СТА-аар илэрсэн нийтлэг зөрчил, зөрчигдөж буй хууль тогтоомжийн заалт, хэрэгжээгүй шийдвэрийн хэрэгжилтийн талаар танхимаар болон цахим, газар дээр нь хүрч ажилласнаас Санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийн хэрэгжилт 97.5 хувийн биелэлттэй ажилласан.
- "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх" сэдвийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Прокурор, Тагнуулын байгууллагаас сургалт авснаар албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн.
- Монгол бичгийн сургалтад бүх албан хаагчид хамрагдсан ба анхан шатны сургалтад 6, дунд шатны сургалтад 3 албан хаагч хамрагдсан. Аймгийн Засаг даргын А/274 дүгээр захирамжаар "Үндэсний бичгийн олимпиад"-д 3 албан хаагч оролцож аудитор Б.Нарангэрэл түрүүлж Төрийн аудитын газрын ажилтны ур чадвар, манлайллыг харуулсан.

Оршил

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРААС 2022 ОНЫ ХИЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ҮР ДҮНГИЙН ТАНИЦУУЛАГА



Хамтын ажиллагаа, олон нийт:

Аудитын үйл ажиллагаанд иргэд, олон нийт, харилцагч талуудын оролцоог хангах идэвхжүүлэх зорилгоор “Харилцагч талуудын оролцооны дэд төлөвлөгөө”-нд 16 арга хэмжээ, “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратегийн 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөө”-нд 8 арга хэмжээг тус тус тусган батлуулж, 1, 4-р улирлын биелэлтийг тайлагнан ажиллав. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, үр дүнгийн талаар ахлах аудитор Б.Должмаа орон нутгийн телевизэд ярилцлага өгч, тус ярилцлагыг YAГ-т хүргүүлснээр TV-9 телевиз, Toim.mn сайтаар мэдээлэл түгээсэн байна.

- “Өнөөгийн Баянхонгор” сонинд Баянхонгор аймгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн”, 2023 онд хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын дүнгийн талаар материалыг тухай бүр нийтлүүлэн ажилласан.
- Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Аудитын тайлан мэдээлэл, гүйцэтгэлийн аудитын тайланг энгийн ойлгомжтой инфографик хэлбэрээр боловсруулж “Нээлттэй аудит” цахим хуудаст байршуулж, "Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар" фейсбүүк хуудсаар дамжуулан аудитын үйл ажиллагааг иргэд олон нийтэд түгээсэн.
- Тайлант онд open.audit.mn цахим сайтад санхүүгийн аудитын дэлгэрэнгүй тайлан 129, хураангуй тайлан 133, гүйцэтгэлийн 4, нийцлийн 2 аудитын дэлгэрэнгүй болон хураангуй тайлан, гүйцэтгэлийн аудитын 4 тайлан, нийцлийн аудитын 2 тайланг инфографик хэлбэрээ боловсруулан тус тус open.audit.mn сайтад байршуулсан.
- Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2020-2022 он, 2023 он гэсэн байдлаар Дашбоард хэлбэрээр audit.mn цахим хуудас болон олон нийтийн сүлжээн дэх байгууллагын пейж хуудсаар нийтэд түгээсэн.
- Харилцагч талуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ИНБ-дын сүлжээ төрийн бус байгууллага, Баянхонгор аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл, аймгийн Прокурорын газар, Хөдөө Аж Ахуйн Их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбартай хамтран ажиллах санамж бичгийг 2023.06.15-ны байгуулсан.
- Төрийн аудитын газар Баянхонгор facebook хуудсаар дамжуулан Төрийн аудитын байгууллагын хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон цаг үеийн ажилтай холбоотой 53 мэдээллийг тухай бүр олон нийтийн сүлжээгээр хүргэн ажилласан.
- Аудитын сэдвийн саналыг иргэд олон нийтээс Google, forms программаар олон нийтийн сүлжээгээр 4 иргэнээс 7, ТББ-аас 2 аудитын санал ирүүлснийг хүлээн авч Аймгийн ИТХ-аас ирүүлсэн саналын хамт журмын дагуу холбогдох нотлох баримт үндэслэлтэй тулган шинжилж АНТАГ-ын 2024 онд гүйцэтгэх 2 сэдвийн саналыг ҮАГ-ын ХБТГ-т 2023.06.23-нд 1/366 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- ИНБ-уудын сүлжээ төрийн бус байгууллагатай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн дагуу Төрийн аудитын байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй албан байгууллагын жагсаалтыг 2023.11.16-ны өдрийн 1/627 тоот албан бичгээр хүргүүлэн хамтран ажилласан.
- Шалгагдагч байгууллагуудад нийтлэг гарч буй алдаа, зөрчлүүд, шийдвэрийн хэрэгжилт, хариуцлагын талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж нийт зөрчил 2023 онд 952 бүртгэгдэж өмнөх оноос 6,2 хувиар буурч шийдвэрийн хэрэгжилт статистик мэдээний дүнгээр 2 хувиар өссөн.



Цахим системийн үйл ажиллагаа:

Аудитын болон дэмжих ажлын хүрээнд цахим программыг өдөр тутамд ашиглаж байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системд 269 байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын үе шатны бүх ажлыг журмын дагуу оруулан баталгаажуулж аудитыг гүйцэтгэсэн.
- Able.audit.mn программын "албан бичиг" цэсийг ашиглан албан хэрэг хөтлөлтийг хөтөлж, "Ажил хэрэг" цэсийг ашиглан аудитын хөтөлбөр болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, "Цаг бүртгэл" цэсийг ашиглан албан хаагчдын цагийг бүртгэж, "Захидал", "Олон нийт" болон Able чатыг ашиглан дотоод болон гадаад цахим хэрэглэгч нартай харилцаж байна. Able системийн цаг бүртгэлийн системийг ашиглан ажлын цаг ашиглалтыг бүртгэж цагийн тайланг гарган ажилласан.
- Үндэсний аудитын газарт шууд тайлагнах аудитын мэдээг 14 хоног тутамд ажлын явцыг data.audit.mn системээр дамжуулан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, тайланг word болон PDF болгон байршуулж явцын мэдээллийг шинэчлэн тайлагнан ажиллав.
- Албан хаагчдад сургалтын үйл ажиллагааны хүрээнд surgalt.audit.mn систем ашиглан 3 удаагийн сургалтаар 12 албан хаагч хамрагдаж эцсийн сорилыг цахимаар өгөв.
- Олон нийтэл ил тод мэдээлэх зорилгоор аудит audit.mn болон open.audit.mn сайтуудаар мэдээлэл түгээхээс гадна google-form систем системээр олон нийтээс аудитын сэдвийн санал, аудитын хүрээнд авах санал асуулга зэргийг авсан.
- MSOffice365 суурилсан гүйцэтгэлийн аудитын программыг ҮАГ-аас нэвтрүүлсэнтэй холбоотой 2023 онд хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитыг цахим программд оруулсан.
- ТАГ нь албан хэрэг солилцоонд ҮАГ-тай Able, Орон нутгийн байгууллагуудтай Egr.e-mongolia системийг ашиглаж байсныг ҮАГ-ын МТТ-тэй хамтарч Able системийг ДОСХ системд холбосноор нэг бичгийг 2 системд оруулдаг байдлыг зогсоож техникийн дэвшлийг ажилдаа нэвтрүүлэн бичиг хэргийн ажилтны ажлын ачааллыг тодорхой хэмжээгээр бууруулсан.


Авлига, ашиг сонирхол, ёс зүй, хасхом:

ҮАГ-ын Тамгын даргын 2023.03.30-нд баталсан Төрийн аудитын байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, Баянхонгор аймгийн Засаг даргын 2023.01.23-ны өдрийн А/48 дугаар захирамжаар баталсан “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулж байгаа “Шударга удирдагч ил тод байгууллага” аяны удирдамж зэргийг үндэслэсэн “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Авлигын эсрэг, үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-г дарга, тэргүүлэх аудитораар батлуулан хэрэгжилтийг хангаж 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. ҮАГ-т тухай бүр биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт хүргүүлж ажиллав. Үүнд:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу байгууллагын зөрчил үүссэн тухай 5 мэдэгдлийг ҮАГ-т хүргүүлснийг МУЕА-ын орлогчоор шийдвэрлүүлэн байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан.
- Авлигын эсрэг хуулийн 10, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу ХАСХОМ гаргах албан тушаалтнуудын жагсаалтыг 2022.12.27-ны өдөр ҮАГ-т хүргэж, 2023.02.01-ний дотор ХАСХОМ-ын бүрдүүлэлтийн системд оруулсан мэдүүлгийг хянан баталгаажуулан, тайланг албажуулан 2023.02.24-ний өдөр ҮАГ-т хүргүүлсэн, тайланг хоцроосон, мэдээлээгүй албан хаагч байхгүй.
- ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академиас төрийн албан хаагчдын дунд явуулж байгаа "Авлигаас ангид төрийн алба" цахим сургалтыг 3 түвшинд байгууллагын албан хаагчид суралцаж, гэрчилгээг авсан байна.
- Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тусгах ажлын хүрээнд төсөвт байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд аудит хийх “Номгон аудит” ХХК, “Баянташаагийн эх аудит” ХХК-тай байгуулсан санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх гэрээнд 2 заалтыг нэмж тусгасан

бөгөөд хувийн аудитын компанийн 4 аудитораар ёс зүйг эрхэмлэн, авлигаас ангид байх баталгааг гаргуулан авч, албан тасалгаанд нь байршуулан ажилласан.

- Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчид, Политехникийн коллежийн оюутнуудын дунд "Авлигагүй ирээдүй" сэдэвт гар зургийн уралдаан зарлан, эхний 3 байрыг шалгаруулж, "Дурсамж", мөнгөн шагналаар шагнасан.



- Харилцагч байгууллагуудыг авлигаас ангид байх, урьдчилан сэргийлэх зорилгоор төсвийн хөрөнгөөр "Би авлига авахгүй, өгөхгүй" уриалга бүхий үзгийн сав 17 ширхэг, түлхүүрийн оосор 12 ширхгийг бэлтгэж, холбогдох албан тушаалтнуудад хүргэсэн. Мөн байгууллагын албан хаагчдын 8 албан тасалгааны өрөөний хаалга бүрд монгол бичгээр "Би авлига авахгүй, өгөхгүй" уриа, АТГ-ын дуудлага хүлээн авах 110 дугаарыг оруулсан модон брошюрыг байршуулсан.



- Шалгагдагч байгууллагын төсвийн менежер, санхүүгийн ажилтнуудаас төрийн аудитын байгууллага болон хувийн аудитын компаниас санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхэд авлига, ашиг сонирхлын зөрчил, хүндрэл бэрхшээл гарсан эсэх, цаашид анхаарах асуудал, саналыг google form ашиглан цахимаар төсвийн байгууллагын 85 албан хаагчдаас авч дүнг нэгтгэн байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, аудиторруудад цаашид анхаарах асуудлыг танилцуулсан.

Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт:

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь "Төрийн байгууллага нь төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын танилцуулгыг 2023.01.26-ны өдөр 1/44, 2023 оны эхний хагас жилд гадаадад хувийн болон албан томилолтоор ажилласан албан хаагч байхгүй талаарх 1/357 дугаар албан бичгийг 2023.06.20-ны өдөр Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст хүргүүлж ажилласан.

- Оны эхэнд лац ашиглаж байгаа 10 албан хаагчаар лацны бүртгэлийг баталгаажуулан, тайланд онд томилогдсон 3 аудиторт лацыг хүлээлгэн өгч, тухай бүрд лацны бүртгэлийг баталгаажуулан ажиллав.

- Байгууллагын нийт албан хаагчдаас оны эхэнд 10 ажилтан, 2023 онд шинээр томилогдсон 3 аудитор, хувийн аудитын компанийн аудиторуд нууцын баталгаа гаргаж, нууц хамгаалах ажилтанд бүртгэлд хяналт тавьж ажиллав.
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэгт тайлант онд гүйцэтгэсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын тайланг албан бичгээр тухай бүрд хүргүүлж ажилласан.
- Тайлант онд гадаад улсад зорчих хүсэлт гаргасан 2 ажилтны гадаадад зорчсон тухай илтгэх хуудсыг тухай бүр Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст хүргүүлсэн, 12 дугаар сард гадаадад зорчсон албан хаагчдын судалгааг хүргүүлнэ.
- Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст хүсэлт хүргүүлэн, байгууллагын нийт албан хаагчдад нууц хамгаалах ажилтны амьдралаас сэдэвлэн хийсэн "Сонголт" богино хэмжээний киног танилцуулж, цаашид анхаарах асуудлыг албан хаагчдад мэдээлсэн.

Архив, бичиг хэргийн хөтлөлт:

Төрийн аудитын үйл ажиллагаанд аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх харилцагч талуудын оролцоог хангах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг Дарга, тэргүүлэх аудитораар 2023.03.14-нд батлуулж 2023 онд 11 ажил хийхээр төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллаж тайланг улирал бүр УАГ-ын ЗХЭЗГ-т хүргүүлсэн.

- Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх 18 ажил хийхээр дэд төлөвлөгөөг батлуулсан бөгөөд дэд төлөвлөгөөний 2023 оны 2-р улирлын хэрэгжилтийг 2023.06.28, 3-р улирлын хэрэгжилтийг 2023.09.29, жилийн эцсийн хэрэгжилтийг 2023.11.20-ны өдөр хүргүүлсэн.
- Архивын үйл ажиллагааны 2023 оны 1-р улирлын тайланг 2023.04.04, 2-р улирлын тайланг 2023.06.23, 3-р улирлын тайланг 2023.09.29, жилийн эцсийн тайланг 2023.11.20-ны өдөр бэлтгэн тайлагнаж УАГ-ын ЗХЭЗГ-т хүргүүлсэн.
- “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-д заасны дагуу дарга, тэргүүлэх аудиторын тушаалыг үндсэн үйл ажиллагааны чиглэлээр буюу “А” тушаал 29, хүний нөөцийн чиглэлээр буюу “Б” тушаал 12 тус тус ангилан бүртгэж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
- Тус байгууллагад 2023 оны эхний 11 сарын байдлаар 748 албан бичиг ирснийг Able программ болон бүртгэлийн дэвтэр ашиглан бүртгэл хөтлөн холбогдох албан тушаалтнуудад шилжүүлсэн, байгууллагаас гаргасан 766 албан бичгийг цаасаар болон able.audit.mn, erp.e-mongolia.mn системд ашиглан бүртгэл хөтлөн тухай бүрд байгууллагуудад хүргүүлж ажилласан. Мөн 2023 онд аудитаар тогтоосон 187 төлбөрийн акт, 223 албан шаардлагыг тухай бүр нь баталгаажуулан хүргүүлж байгууллагад үлдэх хувийг PDF файлыг дарааллын дагуу үүсгэн цахим хэлбэрээр хадгалж, цаасан баримтыг үдэж архивын нэгж болгосон.
- Үндэсний аудитын газрын 2023.04.04-ний өдрийн 02/30 дугаар албан бичгийн хүрээнд 2022 онд гүйцэтгэсэн санхүү, гүйцэтгэл болон нийцлийн аудитын материалыг ажилтнууд архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн баримттай тулгаж, тооллого хийсэн.
- Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/569 дүгээр захирамжийн дагуу дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/20 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг байгууллагын архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт хамгаалалтад нэгдсэн тооллого зохион байгуулж тооллогын дүнг даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1/545 дугаар албан бичгээр Баянхонгор аймгийн Төрийн архивын тасагт хүргүүлсэн.
- Хэвлэмэл хуудасны зарцуулалтад шалгалт тооллого хийхэд төлбөрийн акт 187, албан шаардлага 223, албан бичиг 766 тус тус баталгаажсан дүнг дарга, тэргүүлэх аудиторт танилцуулж хүчингүй болсон 305 албан хэвлэмэл хуудасны 32410 төгрөгийн төлбөрийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн ажиллав.
- Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/583 дугаар захирамжийн дагуу дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/23 дугаар

тушаалаар томилогдсон ажлын хэсэг байгууллагын тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, дардас, хэвлэмэл хуудасны тооллогыг зохион байгуулж тооллогын дүнг даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 1/628 дугаар албан бичгээр Баянхонгор аймгийн Төрийн архивын тасагт хүргүүлсэн.

- Аймгийн архивын тасагтай хамтран ажиллах гэрээ, “Цахим архив–Баянхонгор” хөтөлбөр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын байнга хадгалах 2020 оны Байнга хадгалах–32 хадгаламжийн нэгжийг дансны хамт, 2019 оны Байнга хадгалах–38 хадгаламжийн нэгжийг дансны хамт цаасан болон цахим баримтыг тус тус 2023.06.06-ны өдөр аймгийн Төрийн архивын тасаг актаар хүлээн авч хавсралт 4 маягтын дагуу баталгаажуулж өгсөн.
- Архивын ажилтан нь архивын өрөөнд байвал зохих галын аюулгүйн тэмдэг, галын хор, хүрз, температур болон чийг хэмжигч, элс, ус хадгалах сав, баримт зөөх уут, камержуулалд зэрэг шаардлагатай багаж хэрэгслийн бүрэн байдалд хяналт тавин, өрөөний агааржуулалт температурыг тогтмол шалгаж, стандартын дагуу хяналт тавин ажиллав.

Өргөдөл, гомдол:

Тус байгууллагад санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор иргэнээс 2 өргөдөл, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас санхүүгийн тайлан өгөх хугацааг сунгаж өгөх 2 өргөдөл, цахим архивд баримт хүлээлгэн өгөхтэй холбоотойгоор аудитын тайлан хуулбарлаж өгөх 7 өргөдөл, ажилд орохыг хүссэн 3 өргөдөл, байгууллагын албан хаагчдаас ажлаас чөлөөлөгдөх 1 өргөдөл, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх 1 өргөдөл, цалингүй чөлөө хүссэн 2 өргөдөл, тэтгэмжийн зөрүү олгохыг хүссэн 1 өргөдөл, алба хаасан хугацааны нэмэгдэл нэмүүлэх 1 өргөдөл, дэмжлэг хүссэн 1 өргөдөл нийт 21 өргөдөл ирснээс 20 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, дэмжлэг хүссэн 1 өргөдлийг ҮАГ-т албан бичгээр хүргүүлсэн. Нууцлалтай 2 өргөдлийг нууцын ажилтан бүртгэж, 19 өргөдлийг Able.audit.mn программд бүртгэсэн.

- Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2023 оны 1-р улирлын мэдээг 2023.04.03-ны өдрийн 1/250, 2-р улирлын мэдээг 2023.06.30-ны өдрийн 1/382, 3-р улирлын мэдээг 2023.10.03-ны өдрийн 1/471 дүгээр албан бичгээр хүргүүлж ажиллалаа.


ДОЛООДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Санхүүжилтийн орлого



2023 оны эхэнд 555.1 сая төгрөг батлагдсан ба Үндэсний аудитын газрын 2023.08.01-ний өдрийн 02/1424 тоот албан бичгээр Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан 60.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 615.5 сая төгрөгөөр төсвийг тодотгон ирүүлсэн сар улирлын хуваарийг даган мөрдөж байна.

Зардлын зарцуулалт




Тайлант онд 615.5 сая төгрөгийн төсөв батлагдсан ба хүлээгдэж буй гүйцэтгэлээр 554.2 сая төгрөг зарцуулж 90 хувийн гүйцэтгэлтэй байна

Хүснэгт№ 2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

Нийт зарлагын дүн	615,530.20	554,235.57	61,294.63	90.0
Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	474,144.30	421,277.34	52,866.96	88.9
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	60,615.40	52,511.22	8,104.18	86.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	703.70	703.70	-	100.0
Хангамж бараа материалын дүн	10,276.60	10,276.60	-	100.0
Бичиг хэрэг	3,539.10	3,539.10	-	100.0
Тээвэр, шатахуун	5,781.80	5,781.80	-	100.0
Шуудан холбоо	306.50	306.50	-	100.0
Бага үнэтэй түргэн элэгдэх зардал	649.20	649.20	-	100.0
Томилолт зочны зардал	15,161.70	15,161.70	-	100.0
Дотоод албан томилолтын зардал	15,161.70	15,161.70	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний дүн	2,993.30	2,669.81	323.49	89.2
Төлбөр хураамж бусад	1,470.30	1,470.30	-	100.0
Даатгалын үйлчилгээ	1,200.00	1,000.00	200.00	83.3
Тээврийн татвар	132.00	85.98	46.02	65.1
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44.00	22.00	22.00	50.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	147.00	91.53	55.47	62.3
Бараа үйлчилгээний бусад зардал	402.20	402.20	-	100.0
Хичээл практик зардал	402.20	402.20	-	100.0
Ажил олгогчоос олгосон тэтгэмж, урамшуулал	51,233.00	51,233.00	-	100.0
Эх үүсвэрийн дүн	615,530.20	615,530.20	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	615,530.20	615,530.20	-	100.0

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого



Нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банк дахь 100030024401 тоот дансанд 2022 оны эцэст улсын төсөвт татан төвлөрүүлсэн 6.5 сая, орон нутгийн өмчит аж ахуй нэгжээс 13.2 сая, ХАК-ын санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэсэн ажлын үйлчилгээний төлбөрт 13.8 сая нийт 33.5 сая төгрөг төвлөрснөөс ХАК-тай хийсэн гэрээг дүгнэж Глобал аудит ХХК-д үйлчилгээний төлбөр 9.3 сая, Номгон аудит ХХК-д 11.0 сая төгрөгийг шилжүүлж 2023 оны 11 сарын 17-ны байдлаар 13.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сангийн сайдын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-д заасны дагуу хамт олны хурлын шийдвэрээр байгууллагын албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр саналыг ҮАГ-т хүргүүлсэн.

Санхүүгийн мэдээ тайлан

Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг Мишээл Од ХХК-аар хийлгэн “Зөрчилгүй санал” дүгнэлтийг авсан болно.

- Мөн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, НДШ-н НД7,8 мэдээ сар бүр, татварын тайланг улирал бүр гаран холбогдох байгууллагад нь, санхүүгийн эхний хагас жилийн тайланг гаргаж ҮАГ-т цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.
- Байгууллагын хөрөнгийн тооллогыг Дарга, Тэргүүлэх аудиторын 2023 оны 06 сарын 14-ны өдрийн А/14 тоот тушаалаар Тооллогын комисс томилогдон 06 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн ба ТӨБЗГ-ын <http://pcsp.gov.mn/> системд байгууллагын 2022 оны хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүрэн оруулсан .
- Баянхонгор аймагт ажиллаж байгаа ТӨБЗГ болон аймгийн ОНӨГ-аас томилогдсон ажлын хэсгийн зохион байгуулсан сургалтад 2022.06.19-ны өдөр хамрагдаж, хадгалалт хамгаалалт,

бүртэл тооцоо, байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа тайлан мэдээнд үнэлэлт дүгнэлтийг хийж ТӨБЗГ-тай хийсэн “Өмч эзэмшлийн гэрээ”-г дүгнэж гэрээг сунгасан. Төрийн өмчийн Улсын тооллого, үзлэгээр 96 хувь буюу “хангалттай сайн” үнэлэгдлээ.

- Төрийн аудитын байгууллагад Европын холбооны санхүүжилттэй “Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн хүрээнд “Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийн арга зүй” сургалтыг ҮАГ-аас 2023 оны 06 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд Улаанбаатар зохион байгуулагдсан ба тус сургалтад хамрагдсан.
- Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны төсвийн төслийг боловсруулан ҮАГ-ын ЗХЭЗГ-т 2023.06.06-ны өдрийн 1/334 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Шилэн дансны мэдээллийн талаар



Шилэн дансны тухай хуулийн дагуу бүтэн жилээр байршуулах 11 мэдээллээс хугацаа болсон 5 мэдээлэл, сар бүр байршуулах 4 төрлийн 40 мэдээ, хагас жилээр байршуулах 4 мэдээ, тухай бүр байршуулах 9 төрөл 99 мэдээ, нийт 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулсан.